



Japan International Cooperation Agency




More Equitable and Sustainable Growth for Mongolian People

- Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Нэгдсэн Судалгаа-
(MONDEP) үр дүнгээс

Кацүхидэ Нагаяма, Ph.D.
2018 он 9 сарын 27

Агуулга

- 
- 1. Монгол улсын макро эдийн засгийн байдал, цаашдын таамаглал**
 2. Аж үйлдвэрийн голлох бодлого болон нөөц бололцоо
 3. Үндэсний хөгжлийн тэнцвэртэй цогц бодлогын асуудал
 4. Орон зайн хөгжлийн тэнхлэгт суурилсан стратеги хөгжлийн корридор
 5. Илүү шудрага, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд

Макро эдийн засгийн байдал, ирээдүйн таамаглал

⇒ Уул уурхайн том төслийг хэрэгжүүлэхийн тулд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжин, макро эдийн засгийн бодлого явуулснаар **2011-13 онд эдийн засаг огцом өссөн.**

⇒ Гэвч, экспортын **90% ашигт малтмал төдийгүй, нийт экспортын 90%-г БНХАУ руу** гаргадаг эмзэг эдийн засагтай.

⇒ **Гадаадын хөрөнгө оруулалт, нүүрсний дэлхийн зах зээл дэхь үнийн уналтаас үүдэн эдийн засаг хямралд ороод байна.** Үүний гол шалтгаан нь хөрөнгө оруулалтын орчин ил тод бус, БНХАУ эдийн засгийн хямрал, ашигт малтмалын дэлхийн зах зээлийн үнийн уналт юм.

⇒ **Валютын орлого буурч, төсвийн алдагдал ихэссэн тул мөнгөний хатуу бодлогод шилжсэн.** Банк, санхүүгийн салбарын ашиггүй зээл өсөх зэргээр хямрал гүнзгийрч байна.

⇒ **Ойрын хэдэн жилдээ,** гадаадын зээл санхүүжилтийн эргэн төлөлт зэрэг эрсдэл их, санхүү төсвийн танах бодлого, гадны шууд хөрөнгө оруулалтыг сэргээх хэрэгтэй.

2018 оноос хойш ?

Гэхдээ **урт хугацаанд авч үзэхэд,**

ОУВС болон Дэлхийн банкны таамгаар, Оюу Толгой болон уул уурхайн бусад том төслийн хөрөнгө оруулалт, ашигт малтмалын экспорт өссөнөөр **эдийн засгийн өсөлт болон орлогын түвшин нэмэгдэх бололцоо** бий.

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

Үндсэн үзэл баримтлал:

Засгийн газар солигдсон 4 хөгжлийн үзэл баримтлал хэвээр хэрэгжинэ.

Зорилт 1 :
Эдийн засгийн тогтвортой хөгжил
ХАА
Аялал жуулчлал
Аж үйлдвэр
Эрчим хүч
Дэд бүтэц

Зорилт 2 :
Нийгмийн тогтвортой хөгжил
Нийгмийн тэгш байдал
Эрүүл мэндийн чанартай тогтолцоо
Мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх
Хүний нөөцийг хөгжүүлэх

Зорилт 3 :
Ногоон хөгжил
Усны нөөцийн менежмент
Ундны усан хангамж
Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
Хүлэмжийн хийг бууруулах

Зорилт 4.
Засаглал, бизнесийн орчин
Бизнес эрхлэх орчин
Татварын тогтвортой орчинг бүрдүүлэх
Дотоод гадаадын хөрөнгө оруулалтын орчин

Зорилт

Макро эдийн засаг → **6.6% хувийн дундаж өсөлт**

1 хүнд ногдох ҮНО → **4,280 ам.дол (2014 он) аас 17,500 ам.дол (2030 он)**

Улсын төсвийн бодит төлөвлөлт → өрийн менежмент, хяналт

2014 ДБ (ам.доллар)

БНХАУ	7,600
Казакстан	13,000
Турк	10,000
Грек	22,000

Эдийн засаг, Нийгэм, Ногоон хөгжил 3 үндсэн бодлого

Эдийн засгийн хөгжил → **ХАА, Аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжил**

Нийгмийн хөгжил → **ядуурлыг эцэслэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрүүл мэнд, боловсролын тогтолцоог сайжруулах**

Ногоон хөгжил → **Ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох**

Макро эдийн засгийн таамаглал

Таамаглал загвар:


Монголын эдийн засаг (бүтээгдэхүүний хэмжээ) ашигт малтмал, нүүрсний экспорт, ХАА салбарын хөгжлөөс хараат

хувилбар:

- хувилбар 1: уул уурхай, ХАА салбар аль аль нь тогтвортой өсөлттэй
- хувилбар 2: Уул уурхай тогтмол өсөлттэй, нүүрсний салбар уналтад, ХАА салбар тогтвортой

		2020	2025	2030
Scenario 1	Mining sector	15%	15%	12%
	Coal Export	10%	20%	18%
	Agriculture sector	10%	15%	15%
Scenario 2	Mining sector	8%	4%	3%
	Coal Export	4%	2%	2%
	Agriculture sector	10%	13%	15%

Макро эдийн засгийн тооцооны үр дүн




※) хувилбар 2 Тогтвортой хөгжлийн бодлогын зорилт эдийн засгийн дундаж өсөлт 6.6% тэй ижил өсөлтийн .


ДНБ ний өсөлтийн хэмжээ

2012 он хүртэл, 2009 оноос бусад онд дотоодын хэрэглээ болон хөрөнгө оруулалтын хувь өндөр байсан хэдий ч 2013 оноос хойш хөрөнгө оруулалт зогсонги байдалтай байна.


ДНБ өсөлтийн хэмжээ



Агуулга

- 
1. Монгол улсын макро эдийн засгийн байдал
 2. **Аж үйлдвэрийн голлох бодлого, нөөц бололцоо**
 - i. **Нэмүү өртөг шингээсэн аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд**
 - ii. **ХАА салбарыг тогтвортой хөгжүүлэхийн тулд**
 - iii. **Уул уурхайн салбарын түүхий эд баялагын экспортыг өөрчлөх**
 - iv. **Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн хөгжлийн багана болгох**
 3. Үндэсний хөгжлийн тэнцвэртэй, цогц бодлогын асуудал
 4. Орон зайн хөгжлийн тэнхлэгт суурилсан стратеги хөгжлийн корридор
 5. Илүү шударга, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд

Уул уурхайгаас хараат аж үйлдвэрийн бүтэц




эх сурвалж : МҮСХ

<ДНБ-ний бүтэц>

- Эрдэс баялаг : 17%
- ХАА : 13%
- үйлдвэрлэл : 8%
- барилга : 5%

<Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц>

- Эрдэс баялаг : 60%
- Үйлдвэрлэл : 30%
- Эрчим хүч : 10%




эх сурвалж : МҮСХ

Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогын зорилт (6 сарын 22-нд УИХ-аар батлагдсан)

1. Аж үйлдвэрийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх ;
2. Аж үйлдвэрийн **хөгжлийн бүсийг тодорхойлон** Монгол улсын аж үйлдвэрийн нэгдсэн зураглалыг экосистем, хүн амын нутагшил, суурьшил, түүхий эдийн нөөц, дэд бүтцийн бодлоготой уялдуулан боловсруулах ;
3. Аж үйлдвэрийн **тэргүүлэх чиглэлүүдийг** тодорхойлж, **үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг** цогцоор төлөвлөн хэрэгжүүлэх ;
4. Аж үйлдвэрийн салбарт төр, шинжлэх ухаан, хувийн хэвшлийн үр ашигтай хамтын ажиллагааг дэмжих ;
5. Дэвшилтэт техник, технологи, иновацид суурилсан, эдийн засаг, нийгмийн үр ашиг бүхий боловсруулах, дахин боловсруулах, бүтээлч аж үйлдвэрлэлийг **хөрөнгө оруулалт**, санхүүгийн бодлогоор дэмжих ;
6. Аж үйлдвэрийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
7. **Худалдаа, үйлчилгээний салбарын хөгжих таатай орчинг** бүрдүүлэх, экспортыг төрөлжүүлэх ;

ХАА-н үйлдвэр, технологийн паркийн тэргүүлэх байршил (аж үйлдвэрийн бодлого) аж үйлдвэрийн парк, чөлөөт бүс



Эх сурвалж: хуучин Аж үйлдвэрийн яам

Аж үйлдвэрийн салбарын гол чиглэл

- Уул уурхай голлосон бүтэц (үйлдвэрлэлийн салбар сул)
- Далайд гарцгүй тул тээврийн зардал их
- МАА-н арвин нөөц баялагтай



- **Төрийн бодлогын чиглэл**



- **Тэргүүлэх салбар (ХАА·уул уурхайн боловсруулах үйлдвэр) төвлөрүүлэх, технологи (тогтолцоо, мөнгө санхүү)**
- **Логистикийн сүлжээг боловсронгуй болгох**
- **Худалдаа үйлчилгээ, гадаад худалдааг дэмжих**
- **Хүний нөөцийн хөгжил, сургалт, үйлдвэрлэл төрийн хамтын ажиллагаа**

Аж үйлдвэрийн хөгжилд анхаарал хандуулах салбар болон тэдгээрийг дэмжих бодлогод тавих санал

1. ХАА-н Монгол хувилбарын 6 үндсэн аж үйлдвэрлэлийн аж үйлдвэрийн төрөлжүүлэх

【зөвлөмж 1】 : Өрсөлдөх чадвар бүхий ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлд үзүүлэх дэмжлэг

【 зөвлөмж 2】 : ХАА-н үйлдвэр, технологийн паркийн боловсруулах үйлдвэрийг төрөлжүүлэх , зах зээлийн ханш тогтооход үзүүлэх дэмжлэг

2. Стратегийн салбар дахь нийлүүлэлтийн гинжин хэлхээг хөгжүүлэх замаар төрөлжүүлэх (жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх стратеги)

【 зөвлөмж 3】 : Нийлүүлэлтийн гинжин хэлхээг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрийг дэмжих

【 зөвлөмж 4】 : Олон улсын нийлүүлэлтийн гинжин хэлхээнд холбогдоход үзүүлэх дэмжлэг

【 зөвлөмж 5】 : Үйлдвэрийн хэрэглээний шинэ бүтээгдэхүүн бий болгоход чиглэсэн дэмжлэг


3. Эрчим хүчийг орон нутагтаа үйлдвэрлэн хөнгөн аж үйлдвэр, сэлбэгийн үйлдвэрлэлийг төрөлжүүлэх

【 зөвлөмж 6】 : Эрчим хүчийг түшиглэсэн орон нутгийн хөгжил дэхь аж үйлдвэрийн дэмжлэг

4. Одоо байгаа аж үйлдвэрийг дахин сэргээх замаар аж үйлдвэр дэмжих

【 зөвлөмж 7】 : Технологийн мэдээлэл, судалгаа шинжилгээнд чиглэсэн дэмжлэг


Аж үйлдвэрийн голлох бодлого, нөөц бололцоо

- i. Нэмүү өртөг шингээсэн аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд
-  ii. **ХАА салбарыг тогтвортой хөгжүүлэхийн тулд**
- iii. Уул уурхайн салбарын түүхий эд баялагын экспортыг өөрчлөх
- iv. Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн хөгжлийн багана болгох



Малын сүргийн бүтцийн өөрчлөлт сүүлийн 50 жил

(x 1,000)



1 : 1 : 7 : 3 : 0.5

■ Horse ■ Cattle ■ Sheep ■ Goat ■ Camel

Цаашдын мал аж ахуйн хөгжлийн үндсэн чиглэл

Цаашид эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлнэ. Нүүдлийн **уламжлалт мал аж ахуй**, цаашид ч Монгол улсын МАА-н үндэс хэвээр хадгалагдана.



Бэлчээрийн доройтлоос сэргийлж, олон талын үйлдвэрлэгчдийн оролцоотой, улирал болон орон нутгийн шалтгаалсан үнийн хэлбэлзэлгүй **Монгол онцлогыг тусгасан хосолсон мал аж ахуйг** хөгжүүлнэ.

МАА хөгжлийн үндсэн 4 стратеги

- ◆ Эрүүл мал аж ахуйг хөгжүүлэх
- ◆ Эрүүл зах зээлийн орчинг бий болгох
- ◆ Суурь технологи, дэд бүтцийг сайжруулах
- ◆ Бизнесийн чадамжийг нэмэгдүүлэх

Эрүүл зах зээлийн орчинг бий болгох

1. Эдийн засгийн тусгай бүс (ХАА-н үйлдвэр, технологийн парк)
 - 1) МАА, газар тариалан хосолсон эргэлтэт үйлдвэрлэлийн тогтолцоо → МАА (мах, сүү), тариалан, тэжээлийн үйлдвэрлэлд суурилсан эргэлтэт тогтолцоог хөгжүүлэх
 - 2) Комбинат хэлбэрийн боловсруулалт, тээвэрлэлт → үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлтийг цогцоор нь шийднэ.
 - 3) Малын халдварт өвчингүй тусгай бүс → шүлхий өвчингүй бүсийг бий болгон, экспортыг нэмэгдүүлэх
2. Агро технологийг дахин сэргээх
 - 1) Тэжээлийн үйлдвэрлэлийг (хадлан бэлтгэл) сэргээх
 - 2) Сүүний фермийн аж ахуйг сэргээх
3. Шинэ нэмүү өртгийн гинжин хэлхээг бий болгох
 - 1) Импортыг орлох
 - 2) Экспортыг нэмэгдүүлэх



◆ Шинэ бизнесийн загвар бий болгох

Гэрийн тэжээвэр амьтны хоол

Монголд малын туурай, шөрмөс, яс үнэгүй шахам хаягддаг
Японд малын туурай, шөрмөс, яс зэргийг тэжээвэр амьтны
хоол болгох хэрэглээ ихэссэн.

<асуудал> боловсруулалт, зах зээл олох



Боловсруулал
тыг хэн хийх
вэ?



Зураг: MONDEP (зүүн: Мах импекс ХХК, баруун: OFE ХХК)

● Пласента (эхэс)

- ✓ эм бэлдмэл, гоо сайхан, нэмэлт бүтээгдэхүүн гм
- ✓ Японы зах зээлд гахай, гүүнээс бусад эхэс боломжгүй
- ✓ **Одоо импортлогч: БНХАУ, Вьетнам (гахай) Киргиз (гүү)**

● Халал мах (ялангуяа хонь, ямаа)

- ✓ Ислам шашинтай хүн ам, зах зээл өсч буй

➔ **Япон зах зээл: ойр. 100 мян. хүн
жилд 54 тэрбум иений зах зээл***

<асуудал> оновчтой бэлтгэн нийлүүлэх арга,
анхан шатны боловсруулалтыг сэдэх

<асуудал> шүлхийгээс сэргийлж дулааны
аргаар боловсруулалт хийх

◆ Шинэ бизнес загварыг бий болгох

Төрөл бүрийн боловсруулсан бүтээгдэхүүн гаргах нөөц бололцоо

- ХОНИНЫ НООС ➔ барилга, автомашины дулаалга гм
- цагаан идээ (ялангуяа сарлаг, ингэ) ➔ ховор
- арьс шир ➔ их хэмжээний, олон төрлийн ширний шинэ хэрэглээ
- нэхмэл (ялангуяа сарлаг, ингэ) ➔ ховор үнэ ЦЭНЭТЭЙ
- яс, өөх ➔ яс: барилгын материал, өөх: судасны хатуурлаас сэргийлэх
- казейн ➔ тусгай хэвлэлийн цавуу
- 5 хошуу малаас гадна ➔ тахиа, гахайн аж ахуй
- малын өтөг бууц ➔ ургамлын харшил, аллергины эм

Хүнсний нэмүү өртгийн гинжин хэлхээ бий болгох



【зөвлөмж】 ХАА бизнесийн хөгжил: Business Potentials

Нутгийн онцлогт бүтээгдэхүүн болгон тарьж, орон нутгийг хөгжүүлэх, сэргээх

⇒ **«Дотоодын хэрэгцээг хангах»**

⇒ **Экспортын чиглэлтэй бүтээгдэхүүнээр экспортыг дэмжих**



Чацаргана



Зөгийн бал




Чихэр өвс (үндэс,)



Гурвалжин будаа

Аж үйлдвэрийн голлох бодлого, нөөц бололцоо


- i. Нэмүү өртөг шингээсэн аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд
- ii. ХАА салбарыг тогтвортой хөгжүүлэхийн тулд
-  **iii. Уул уурхайн салбарын түүхий эдийн экспортыг өөрчлөх**
- iv. Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн хөгжлийн багана болгох

Зөвлөмж : Уул уурхайд түшиглэсэн аж үйлдвэрийг хөгжүүлэх үндсэн чиглэл

- Нүүрсний үйлдвэрлэлийн 30 орчим хувь нь дотоодын хэрэгцээ байдаг, цаашид ч тогтвортой өсөх хандлагатай.
- Бусад уул уурхайн бүтээгдэхүүн экспортын чиг хандлагатай, зэсийн баяжуулах болон төмөрлөгийн үйлдвэрлэлд эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ч дотоодын хэрэгцээ төдийгөөр хязгаарлагдах тул үйлдвэрлэл хөгжүүлэхэд хүндрэлтэй.
- Эцсийн бүтээгдэхүүн болсон зэс, төмрийн экспортод гаргах зах зээл олох, тээвэрлэлтийн зардал асуудал болно.
- **Нүүрсний нэмүү өртгийн гинжин хэлхээ** бий болгох холбогдох үйлдвэрийг дэмжих нь аж үйлдвэрийн хөгжилд дэмжлэг үзүүлэх орон нутгийн хөгжлийн стратеги хэмээн санал болгож байна.

Нүүрсний нэмүү өртгийн гинжин хэлхээ

- I. Нүүрс баяжуулах үйлдвэр байгуулснаар нэмүү өртөг шингэн, завсрын хаягдлыг ашиглах
- II. Нүүрснээс хий гаргах/шингэрүүлэх үйлдвэр байгуулан эрчим хүчийг төрөлжүүлэн химийн үйлдвэрийг хөгжүүлэх
- III. SVM/UCG ашигласан орон нутагт эрчим хүч хангамжийн систем бий болгох




Нүүрсний нэмүү өртгийн гинжин хэлхээ

Зөвлөмж : Нүүрсний нөөцийг ашиглан нэмүү өртгийн гинжин хэлхээ бий болгох


СВМ/UCG ашиглан орон нутгийн эрчим хүч хангамжийн систем бүрдүүлэх

- Орон нутгийн эрчим хүчний нөөц баялгийг үр дүнтэй ашиглах
- Орон нутаг т эрчим хүч үйлдвэрлэж, хэрэгцээгээ хангах : цахилгаан дамжуулалтын үеийн алдагдлыг багасгах, нүүрсний тээвэрлэлт бууруулах, орон нутгийг хөгжүүлэх
- Цахилгаан, дулааны сүлжээг CNG сүлжээтэй хослуулах : эрчим хүчийг төрөлжүүлэх
- Биогазыг үр дүнтэй ашиглах, сэргээгдэх эрчим хүчтэй хослуулах : эрчим хүчийг төрөлжүүлэх
- Ялгарсан CO₂ боловсруулах, ялгаруулалтын тэглэх : CO₂ ялгаралтуулалтыг багасгах




СВМ/UCG орон нутгийн
Эрчим хүчний систем схем
Source: www.uri-net.com

Аж үйлдвэрийн голлох бодлого, нөөц бололцоо

- i. Нэмүү өртөг шингээсэн аж үйлдвэрийг хөгжүүлэхийн тулд
- ii. ХАА салбарыг тогтвортой хөгжүүлэхийн тулд
- iii. Уул уурхайн салбарын түүхий эд баялагын экспортыг өөрчлөх
-  iv. **Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн хөгжлийн багана болгох**

Аялал жуулчлалын боломжийг нэмэгдүүлэх аялал жуулчлалын хөгжлийн стратеги



Эх сурвалж: ҮСХ, ЖАЙКА-ийн судалгааны баг

Монголын аялал жуулчлалын салбарын үнэлгээ


141 орноос **99**-р байранд байна (Азийн бусад орнууд; Япон 9, Хятад 17, Малайз 25, Тайланд 35-р байр)

Эх сурвалж : World Economic Forum, Travel & Tourism Competitiveness Index Ranking 2015


Тэргүүлэх салбар 1. Бизнес аялал жуулчлалыг хөгжүүлэх

Тэргүүлэх салбар 2. Байгаль соёлын нөөцийг хамгаалах

Тэргүүлэх салбар 3. Зам харилцааг сайжруулах




Байгаль, соёлын өвийн хамгаалалтай уялдсан аялал жуулчлалын кластер бий болгох



Зам харилцааг сайжруулах Аялал жуулчлалын нөөц бололцоог нэмэгдүүлэх

- Агаарын чөлөөт бодлого (Open Sky) зуны нислэгийн тоо нэмэгдэнэ
- Төр, хувийн хэвшлийн түншлэлээр (PPP) аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах
- ТХГН-ийн дотно гаднах зам харилцааг сайжруулах, аялал жуулчлалын кластерийг өргөжүүлэх
- Стратеги маркетинг (Ази, Европын зах зээл)
- Орон нутгийн нислэг, төмөр замын зорчигч тээвэрлэлт нэмэгдүүлэхийн тулд онлайнаар билет худалдаа зэрэг мэдээлэл технологийн үйлчилгээг нэвтрүүлэх
- Аялахад тав тухтай зам тээвэр, худалдаа үйлчилгээний байгууламжийг барьж байгуулах (Зам дагуух үйлчилгээний газар Мичино Эки гм)


Агуулга

1. Монгол улсын макро эдийн засгийн байдал, цаашдын таамаглал
2. Аж үйлдвэрийн голлох бодлого болон нөөц бололцоо
-  3. **Үндэсний хөгжлийн тэнцвэртэй, цогц хөгжлийн асуудал**
4. Орон зайн хөгжлийн тэнхлэгт суурилсан стратеги хөгжлийн корридор
5. Илүү шудрага, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд

Тэнцвэртэй хөгжлийн бүтцийг бий болгох

- **Улаанбаатар хотод хэт төвлөрсөн хүн ам**
 ⇒ Орон нутагт хүн амыг суурьшуулах бодлого (нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулах) хэрэгтэй
- **Хот, хөдөөгийн нийгмийн үйлчилгээний ялгаа**
 ⇒ Хөдөө орон нутгийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх хэрэгтэй
- **Аж үйлдвэрийн бүтэц**
 - Хөдөө, орон нутгийн нэг хүнд ногдох ДНБ хэмжээ УБ хотын 70%
 - ХАА салбар нь хөдөө, орон нутгийн голлох аж үйлдвэр
 - Худалдаа, үйлдвэрлэлийн төвлөрөл УБ, төвийн бүсийн тулгуур хотуудад тараан байршуулах


⇒ Монгол улсын эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгахад хотын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөө орон нутагт хүн амын суурьшлын бодлого баримтлах хэрэгтэй.



Улсын хөгжлийн үндсэн чиглэл

1. Орон зайн төлөвлөлтийн гол шугам, дэд бүтэц, зохистой газар ашиглалт
 - Тээвэрлэлтийн нэгдсэн тогтолцоо (автозам, төмөр зам, агаарын тээвэр) , логистик, эрчим хүч, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх
 - Хот суурин газрын өсөлтийн хяналт
 - Тариалан, бэлчээр, ой мод, байгаль хамгаалал, усны нөөцийн нэгдсэн хяналт
2. Улаанбаатар хотын өсөлтийн хяналт, бүсийн тулгуур төвийн хөгжил
 - Эрч хүчтэй том хотын орчинг бүрдүүлэх
 - Орон нутгийн бахархалт тулгуур төвийн хөгжил
 - Стратеги үйлдвэрлэлийн төв (ХАА үйлдвэр технологийн парк, чөлөөт бүс, аж үйлдвэрийн парк) болон зах зээл бий болгох
3. Аялал жуулчлалын улс болон хөгжих, олон улсын харилцааг сайжруулах
4. Байгаль орчны тогтвортой хамгаалал, нөхөн сэргээлт, зохистой ашиглалт
 - Эрчим хүчний нэгдсэн бодлого
 - Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох

Монгол улсын автозамын сүлжээ



Авто замын сүлжээний төлөвлөгөө:

Улаанбаатар – Аймгийн төв

- 32 Чиглэл
- 2016 онд 6 аймаг хатуу хучилтаар холбогдоно

Аймгийн төв – Хилийн боомт

- БНХАУ (7 аймаг нийт 12 боомттой. Үүнээс 7 боомт байнгын, 5 боомт түр үйл ажиллагаатай)
- ОХУ (8 аймаг нийт 27 боомттой, Үүнээс 8 боомт байнгын үйл ажиллагаатай, 19 боомт

Аймгийн төв – Аймгийн төв

- Сүлжээний оновчтой төлөвлөгөө хэрэгтэй
- Сүлжээний эрэлтийн шинжилгээ хийх


Азийн авто замын хөгжил

- АН3 – 6 эгнээ бүхий хурдны зам
- АН4, АН32 – Хатуу хучилттай зам

Монгол дахь Азийн хурдны зам




Төрөөс төмөр замын салбарт барьж буй бодлого: Уул уурхайд түшиглэсэн төмөр замын сүлжээ



№	Хэсэг	Урт (км)
1	Таван толгой ~ Гашуун сухайт	230
2	Таван толгой ~ Зүүнбаян	400
3	Таван суварга~ Зүүнбаян	200
4	Арц суурь ~ Эрдэнэт	670
5	Нарийн сухайт ~Шивээхүрэн	45

№	Хэсэг	Урт (км)
6	Чойбалсан ~ Хөөт ~ Сайншанд	550
7	Чойбалсан ~ Хөөт ~ Бичигт	320
8	Чойбалсан ~ Нөмрөг	540
9	Чойбалсан ~ Эрэнцав	238
10	Одоо байгаа төмөр замыг хос болгох	1,111

Агуулга

1. Монгол улсын макро эдийн засгийн байдал, цаашдын таамаглал
2. Аж үйлдвэрийн голлох бодлого болон нөөц бололцоо
3. Үндэсний хөгжлийн тэнцвэртэй цогц бодлогын асуудал
-  4. **Орон зайн хөгжлийн тэнхлэгт суурилсан стратеги хөгжлийн корридор**
5. Илүү шударга, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд

Зүүн Азийн бүсийн олон улсын эдийн засгийн хөгжлийн корридор

- Эдийн засгийн хөгжлийн корридор :
 - Бүс нутгийн хүн, бараа, мөнгөний урсгалыг чөлөөлснөөр шинэ зах зээлийг бий болгож, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг эдийн засгийн томоохон үр ашиг нээгдэнэ.
 - Олон улсын корридорын харилцан зорчих лиценз тэй болгосноор тухайн орон бүр худалдаагаа өргөтгөх бололцоотой болно.
- Одоо байгаа бодлого, үзэл баримтлал :
 - Азийн хурдны зам, Мянганы зам, Тал нутгийн зам зэрэг
 - Нэг бүс, нэг зам (худалдааны корридор)
 - ОХУ-ын Алс Дорнодын хөгжлийн хөтөлбөр
 - Түмэн голын төсөлд түшиглэсэн БНХАУ-ын зүүн хойд бүсийн корридор
 - Олон улсын аялал жуулчлалын сүлжээ



Асуудал :

1. ОХУ, БНХАУ-ын олон улсын ачаа тээвэрлэлтийн тогтолцоог ашиглах
2. Олон улсын худалдааны корридорыг бэхжүүлэх
3. Далайд гарцгүй байдлаас ангижрах

Олон улсын ачаа тээвэрлэлтийн корридор Зүүн Азийн зах зээлд ойртох

PLANNED CONSTRUCTION OF NEW RAILWAY INFRASTRUCTURE

“Шинэ төмөр замын төсөл”:

- Нийт замын урт: ~1800 км
- Барилгын зардал : ойролцоогоор 80-90 тэрбум ам доллар (дэд бүтэц, вагон)



Төв Азийн бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрөөс (CAREC) дэвшүүлж буй эдийн засаг, дэд бүтцийн корридор



Хөдөө аж ахуйн нөөцөд тулгуурласан эдийн засгийн корридор




Legend

- Road
- Aimag Center
- Railroad
- Aimag Boundary
- Railway (中国鉄道ネットワーク図より)

Аж үйлдвэрийн хөгжил, уул уурхайн нөөцөд түшиглэсэн эдийн засгийн хөгжлийн корридор

Аж үйлдвэрийн босоо тэнхлэг




Өмнөд бүсийн ашигт малтмалын тэнхлэг

ТАЙЛБАР ЗУРАГ

ЛОГИСТИК ТӨВ, ТЕРМИНАЛУУД	ХҮЧИН ЧАДАЛ
ЗОРЧИГЧ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦОГЦОЛБОР	<ul style="list-style-type: none"> 200 000 дахин 100 000 - 200 000 хургал 20 000 - 100 000 хургал 20 000 хургал
БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ТЕРМИНАЛ	<ul style="list-style-type: none"> Ажлын 100 000 тоннны ажил Цагийн 1 000 000 тоннны ажил Ажлын 10 000 - 100 000 тонн хургал Цагийн 10 000 тонн хургал Ажлын 10 000 тонн хургал Цагийн 10 000 тонн хургал
УУЛ УУРХАЙН ТЕРМИНАЛ	<ul style="list-style-type: none"> 3 000 000 тоннгоо дахин 1 000 000 - 3 000 000 тонн 1 000 000 тонн хургал
МАХНЫ ХӨРГӨЛТТЭЙ АГУУЛАХ	<ul style="list-style-type: none"> 10 000 тоннгоо дахин 3 000 - 10 000 тонн хургал 3 000 тонн хургал
ХҮНСНИЙ НОГООНЫ ЗООРЬ	<ul style="list-style-type: none"> 50 000 тоннгоо дахин 10 000 - 50 000 тонн хургал 10 000 тонн хургал

Гадаад худалдааны корридорын санал



Эдийн засгийн стратеги хөгжлийн корридор, орон зайн хөгжлийн үндсэн хандлага (санал)

Эдийн засгийн корридор хөгжүүлснээр :

Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг уялдуулснаар, хөгжлийн илүү их нөөц бололцоо бүхий эдийн засгийн корридор орон зайн хувьд мэдрэгдэх хэдий ч тэрхүү тэнхлэгийн дагуу дэд бүтцийн санхүүжилт, хөрөнгө оруулалт зэрэг хөгжлийн нөөц баялагийг стратеги төлөвлөлтийн дагуу хуваарилах бодлогын хэрэгжилт нь өргөн удам нутагтай Монгол улсын хөгжилд үр ашигтай.

1. Хөндлөн тэнхлэгийн хөгжлийн корридор

- Өргөн удам нутагт тэргүүлэх стратегийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг дэмжих, үр дүнг нэмэгдүүлэн, дэд бүтцийн ашиглалтын өгөөжийг бататгах хөгжлийн тулгуурыг бий болгоно.
- Зам тээвэр (төмөр зам, төв зам), харилцаа холбоо, мэдээллийн технологи зэрэг дэд бүтцийн сүлжээг бэхжүүлж, зам дагуух бүс нутгийн онцлогт тохирсон хөгжлийн төсөл, хөтөлбөрийг стратегитай хэрэгжүүлснээр газар нутаг ашиглалтын зөрүүг арилган, хэт төвлөрөл болон орон нутаг хоорондын ялгааг арилгана.

2. Бүсийн тулгуур төвийн хот байгуулалт

- Эдийн засгийн тэнхлэгт байрлах хөгжлийн нөөц бололцоо бүхий бүс нутгийн тулгуур төв хотуудад аж үйлдвэрийн хөгжлийн төв байгуулан, тээвэр, холбоог ашиглан үр ашигтайгаар уялдуулан, бүс нутаг хоорондын тэнцвэртэй хөгжлийг бий болгоно.
- Эдийн засгийн нөлөөлийн бүс нутгийн онцлох нэрийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

3. Орон нутагт нутагшуулах

- Орон нутгийн нийтийн аж ахуйн үйлчилгээг сайжруулж, хэт төвлөрлийн асуудлыг шийдвэрлэн, улсын газар ашиглалтын тэнцвэрийг хадгалан, хүний амьдрах орчинг цогцоор нь хөгжүүлнэ.

4. Аялал жуулчлалын хөгжил болон тусгай хамгаалалтын газрын хяналт

- Зам харилцаа, аялал жуулчлалын байгууламж, тусгай хамгаалалтын газрын хяналтыг нэмэгдүүлнэ.



Агуулга

1. Монгол улсын макро эдийн засгийн байдал, цаашдын таамаглал
2. Аж үйлдвэрийн голлох бодлого болон нөөц бололцоо
3. Үндэсний хөгжлийн тэнцвэртэй цогц бодлогын асуудал
4. Орон зайн хөгжлийн тэнхлэгт суурилсан стратеги хөгжлийн корридор
- 5. Илүү шударга, тогтвортой хөгжлийг бий болгохын тулд**



Шудрага, тогтвортой хөгжилд шаардлагатай 5 бодлого

1. Г Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030] зорилтыг хэрэгжүүлэх
2. Улсын нөөц баялаг (ой мод, бэлчээр, тариалан, усны нөөц, ашигт малтмал, аялал жуулчлалын нөөц, биологийн төрөл зүйл) зохистой хэрэглээ, хамгаалалтын хатуу бодлого барих
3. Бүсийн тулгуур төв хотын хөгжлийн загвар бий болгох
4. Алсын хараатай, шилдэг хүний нөөц бэлдэх
5. Гадаадын хөрөнгө оруулалт, технологи, тогтвортой эдийн засгийн суурь бүрдүүлэхийн тулд Ази, Европын орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхижүүлэх

Ашигласан: Монгол Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА) 2016

Нэвтрүүлэх боломжтой Япон технологи, технологи

Салбар	Японы технологи
Сэргээгдэх эрчим хүч	Биомассын технологи/метан хий/хог хаягдлын цахилгаан станц/ эрчим хүч гарган авах цэвэрлэх технологи/нарны эрчим хүчний станц/салхин станц /газрын дулааны эрчим хүч/ усан цахилгаан станц
Нүүрсний ашигтай хэрэглээ	Нүүрс баяжуулах-хуурай баяжуулах/нүүрсний хий, шингэрүүлэх/нүүрсний давхаргаас метан боловсруулж, ашиглах/төмөрлөг, коксын үйлдвэр/ бусад ногоон технологи
Шинэ эрчим хүчний технологи	Устөрөгчийн технологи/төмрийн натри
Логистик	Хөргүүр, хөлдөөгч агуулах /CAS систем (Cells Alive-System)/хөргүүртэй тээвэрлэлтийн систем /RFID систем/ ачаа хүргэлтийн систем
ХАА	Үхрийн махны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх/ малын эрүүл мэндийн хяналт/ шүлхийтэй тэмцэх/ арьс ширний үйлдвэрийн технологи/ органик ХАА/ үнэ ханш тогтоох/ ХАА бүтээгдэхүүний стандарт (MAS)/ ХАА үйлдвэрлэгчдийн орлого нэмэгдүүлэх (зах зээлийн систем)
Аялал жуулчлал/ байгаль орчин	Тусгай хамгаалалттай газрын хяналтыг сайжруулах/үйлчилгээний ажилтаны сургалт,дадлагажуулах тогтолцоо/үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хууль эрх зүй (аялал жуулчлалын хууль гм) /эко санаачлага
Хүрээлэн буй орчин	Бэлчээрийн доройтол/ гар аргаар алт олборлолтыг зогсоох/ уул уурхайн нөхөн сэргээлтийн тогтолцоо
Хог хаягдал	Бактери устгах технологи/ хуванцар боловсруулах технологи/ электрон хог хаягдлыг дахин ашиглах/ биомассын хэрэглээ/ хог шатаах байгууламж/ хог хаягдлыг булаах технологи
Эко	ESCO төсөл/орон сууцны эрчим хүчний систем HEMS/ нарны энерги болон литийн баттерей/ ухаалаг технологи
Үйлчилгээ	24 цагийн үйлчилгээний систем (өргөн хэрэглээний барааны түгээх систем)
Эрүүл мэнд	Алсын зайн оношлогооны систем/PEM гм дэвшилтэт технологи/сувилгаа,асаргаа/ эмнэлгийн шатлалт систем/төрөх, хүүхдийн эрүүл мэнд/оношлогоо/өндөр зэрэглэлийн технологи/нийгмийн эрүүл мэнд
Боловсрол	Цэцэрлэг / дунд сургуулийн хүрэлцээг нэмэгдүүлэх/ ш/у мэргэжлийн ахлах сургуулийн боловсрол гм
Зам, барилгын технологи	Замын суурь, хучилтын стандарт/ гүүр,туннель/ барилгын чанарын технологи/угсралтын хяналт/хүйтэн бүсийн барилгын технологи/аюулгүй ажиллагаа/чанарын хяналт/элсэн шуудайн технологи
Тээврийн систем	ITS (ухаалаг зам тээврийн систем)/хурдны замын SA•PA/мэдрэгчтэй IC карт, FeliCa технологи/Мичино эки/төмөр замын IT шийдэл (e-RAIL Service)
Үйлдвэрлэл	Үйлдвэрийн зориулалтын робот / IT технологи/Business Processing Outsourcing (BPO)
Уул уурхай	Ашигт малтмалын хайгуул/зураглал/уул уурхайн төлөвлөлт/олборлолт•тээвэрлэлтийг автоматжуулах /боловсруулах•нэмүү өртөг шингээх/био шүлтжүүлэг

Монголын эзэнт гүрэн (1206~) түүхэнд 2 дахь эзэнт гүрэн



【2 дахь】 Монголын эзэнт гүрэн (1206~)
Газар нутаг: 33 сая км² (дэлхийн 25%)
Хүн ам: 110 сая (дэлхийн 26%)

【1 дэхь】 Английн эзэнт улс 1922-
Газар нутаг: 34 сая км² (дэлхийн 26%)
Хүн ам: 458 сая (дэлхийн 20%)

【3 дахь】 Испани 1783-
Газар нутаг: 19 сая км² (дэлхийн 14%)
Хүн ам: 68 сая (дэлхийн 12%)

Монголын эзэнт гүрний түүхээс суралцах зүйл :

1. Шилдэг хүний нөөцийг бүрдүүлсэн (**Хүний нөөц**)
2. Хүчит Монгол морийг чухалчилсан (**Ачаа тээвэрлэлтийн стратеги**)
3. Соёлын өв, баялагийг булаан эвдээгүй (**Орон нутгийн засаглал**)



Судалгааны дэлгэрэнгүй тайлан :

- Англи хэл

<http://libopac.jica.go.jp/images/report/P1000030037.html>

- Монгол хэл

<http://libopac.jica.go.jp/images/report/P1000030038.html>

Анхаарал тавьсанд баярлалаа.